

МЭДЭЭЛЛИЙН НИЙГМИЙН МӨН ЧАНАР,
ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Б.Болд-Эрдэнэ*

* МУИС НШУС. Сэтгүүл зүйн тэнхимийн багш, сэтгүүл зүйн доктор, дэд профессор.

Түлхүүр үг: мэдээллийн нийгэм, мэдээллийн даяарчлал, Интернетийн идэвхтэй хэрэглэгч, тоон технологи.

Шинэ үе компьютерийг сонгож байна. Тиймээс ч мэдээллийн нийгмийн тухай ярих цаг болжээ. Гэхдээ мэдээллийн нийгэм хэмээх ойлголтын хүрээнд эрдэм шинжилгээний өгүүлэл бичнэ гэдэг нилээд түвэг бэрхшээлтэй, басхүү маргаантай ажил юм. Үүний шалтгаан нь нэгдүгээрт мэдээллийн нийгэм нь Монголын өнөөгийн ахуй амьдрал, эдийн засгийн байдал, хүмүүсийн сэтгэхүйн хүрээнд эртэдсэн, хөгжил нэвчилт нь эхлэл төдий байгаа, хоёрдугаарт уг асуудлыг тодорхойлохдоо Монголын соёл иргэншлийн өөрийнх нь онцлогийг харгалзан, үнэлэлт дүгнэлт өгөх том зорилт байгаа, гуравдугаарт мэдээллийн технологийн хөгжил өөрчлөлтийн нөлөө хүмүүсийн сэтгэхүй амьдралд ямар нөлөө үзүүлэв гэдэг нилээд маргаантай асуудлыг хөндөж байгаатай холбоотой болно. Тиймээс асуудлыг зүйчилж бус ерөнхий тоймлон, дээр өгүүлсэн зорилтоо нэгтгэн, онолын гэхээсээ, зарим нэг уншиж сонирхож байсан ном өгүүллээс санаа авч өөрийн үзэл бодлоо бичлээ.

Юуны өмнө мэдээллийн нийгэм гэж юу вэ гэдгийг тодорхойлохоос яриагаа эхлэх байх. Мэдээж мэдээл-

лийн нийгэм хэмээх ойлголтыг өрнөдийн төдийгүй, манай судлаач, мэргэжилтнүүд хүртэл өөрөө өөрсдийнхөөрөө тайлбарлаж байгаа. Тэгээд ч энэхүү үг хэллэг анх улс төрчдөөр дамжиж манай нийгэмд хүрсэн тул нэг талаас "хэрэглээний ердийн" мэт нэр томъёо болон үнэ цэнээ алдаж, нөгөө талаас нийгэм эдийн засгийн бүх хүрээнд яригдах болсноор чухам юуг хэлээд байгаа, ямар онцлог нөлөө үр дагавар авчирсныг тодорхойлоход түвэг бэрхшээлтэй байгаа юм. Нөгөө талаар интернет банк, олон улсын нислэгийн тийз зуучлах төв, зайны сургалт, магадгүй и-мэйл дурлал гээд бидний амьдралд бодитоор оршин буй олон өөрчлөлт хувьслын мөн чанарыг нэгтгэн үзэх нь тийм ч амар биш гэдэг нь ойлгомжтой.

Гэвч мэдээллийн нийгэм хэмээх ойлголт нь ямагт компьютер, түүнийг тойрсон шинэчлэлт хувьсал, мега сүлжээ, технологийн хөгжилтэй холбоотой байгаа нь ажиглагдаад байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөн чулуугаар багаж хэрэгсэл, зэвсэг хийж чадсан нь оюун санаа ухамсрын агуу их дэвшил болж, байгалийг эзэмдэх түүх эхэлсэн шиг, дотоод шаталтын хөдөлгүүрийг нээсэн нь аж үйлдвэржилтийн эринийг дагуулсан шиг компьютер гэгч орон зай, цаг хугацааг эзэгнэх бизнес эдийн засгийн хийгээд нийгмийн харилцааны цоо шинэ

иргэншлийн бий болгож байна гэсэн үг. Гэхдээ он цагийн хувьд чулуун зэвсгийн үе хэдэн мянган жилээр тооцогддог бол ном хэвлэх машин бүтээгдсэн нь дөнгөж 500 жилийн өмнөх үйл явдал юм. Бас хүн төрөлхтөн 5000 жил морь тэмээ хөлөглөж байж унаагаа машинаар сэлбэснээ ердөө 20-хон жилийн дараа нисэх онгоц бүтээжээ¹. Харин Интернетийн түүх 1960-аад оны сүүлчээс эхэлдэг боловч арилжааны, олон нийтийн хэрэглээний улмаар мэдээллийн даяарчлал дэлхийн нэгдмэл орон зайг бий

болохуйц мега сүлжээ болсон нь 1991 оноос л эхэлнэ. Гэвч арав хүрэхгүй жилийн дараа буюу 2000 он гэхэд дэлхийн хүн амын 6 хувь болох 360 сая гаруй хүн Интернетэд нэвтэрч, веб сайтын тоо 72 саяд хүрч, өдөрт ойролцоогоор 2 сая хуудсаар мэдээл-

лийнх нь хуудас нэмэгдэх болов². Энэхүү мэдээллийн мега сүлжээний хөгжил өөрчлөлт дээр программ хангамжийн тасралтгүй шинэчлэлт, тоон телевиз радиогийн өсөлт, эдийн засаг санхүүгийн салбар дахь мэдээлэл харилцааны технологийн нөлөөгөөр бий болсон шинэ салбар, ололтууд зэргийг нэмбэл асар том үзүүлэлт гарах нь мэдээж. Гэхдээ энэ бол асуудлын гэгээлэг зэрэг тал. Харин сөрөг зөрчилт тал нь гэвэл ядуу буурай улс орнуудын технологийн хоцрогдол, хэрэглээний ядмаг орчин, эдийн засгийн зүй бус тогтолцоо зэргээс үүдсэн мэдээллийн тэгш бус харьцаа (digital divide) түүнээс гарах үр дагаврыг хэлэх хэрэгтэй. Интернетийн хэрэглээний

үзүүлэлт төвшин Скандинавийн орнуудад хамгийн өндөр байгаа нь дараах тоо баримтаар нотлогдоно. Үүнд 2000 оны сүүлчээр Шведийн нийт хүн амын 56,36%, Норвеги 52,6%, Дани 48,37%, Финлянд 43,93%, хувь нь тус тус Интернет хэрэглэж байгаа дүн гарчээ. Энэ тоо Их Британид 26%, Германд 24% Францад 15% байгаа юм. Харин гэрээсээ холбогддог буюу Интернетийн идэвхтэй хэрэглэгчийнхээ тоогоор Америк 165 сая хүн гэсэн үзүүлэлтээр давамгайлж байна. Гэтэл Молдавийн нийт хүн амын

«

Монголын хувьд 2003 оны байдлаар нийт хүн амын 7,3 буюу 170 мянга орчим хүн Интернетийг ямар нэг байдлаар хэрэглэдэг гэсэн дүн гарчээ. Гэхдээ хэрэглээний 90 шахам хувийг захидал бичих, тоглох, e-майл шалгах эзэлж байгаа нь чанарын талаасаа ядмаг болох нь ойлгомжтой.

»

мянга⁴ орчим хүн Интернетийг ямар нэг байдлаар хэрэглэдэг гэсэн дүн гарчээ. Гэхдээ хэрэглээний 90 шахам хувийг захидал бичих, тоглох, e-майл шалгах эзэлж байгаа нь чанарын талаасаа ядмаг болох нь ойлгомжтой. "Мэдээллийн зуун" хэмээх гурван боть ном бичсэн Мануелл Кастеллс шинэ нийгмийг "компьютер, микрочипийн тасралтгүй шинэчлэлт, цахим ажил, зайны сургалт, банк санхүүгийн мега сүлжээ, хөдөлгөөнт харилцаа холбооны бие даасан шинэ тогтолцоо, генийн инженерчлэлийн эрин, эдийн засаг санхүүгийн даяарчлагдсан зах зээл, дэлхийг бүхэлд нь хамарсан зах зээлийн эдийн засгийн мэдээллийн тогтолцоо, мэдээллийн салбар дахь

дөнгөж 0,34 %, Украйны 0,41 %, Болгарын 2,57%, Оросын 6,3 %, Унгарын 7,2%, Польшийн 7,25%³ гэсэн үзүүлэлттэй байгаа юм. Монголын хувьд 2003 оны байдлаар нийт хүн амын 7,3 буюу 170

ажиллагсдын бодит өсөлт, үзэл суртлын уналт, хүйтэн дайны төгсгөл, хотжилтын шинэ давалгаа, дэлхийн эдийн засаг дахь Ази номхон далайн улс орнуудын хүчтэй нөлөө бодит байр суурь, мэдээллийн сүлжээний шинэ орон зай" хэмээн тодорхойлжээ. Харин монголчуудын хувьд мэдээллийн нийгмийн үзэгдлүүд эхлэл төдий, хот суурин газрын мэдлэг боловсролтой хүрээг хамарсан, өрнөдшилтийн үнэт зүйлийн давалгаагаар хуулбарлагдан нэвчиж буй, төр засгийн тодорхой бодлого үйл ажиллагаа үгүй урсгал шинжтэй байгаа билээ. Өөрөөр хэлбэл, мэдээллийн нийгэм нь манай оронд мөн чанарын, эрэлт хэрэгцээний, эдийн засаг нийгмийн бодит байдлын үр дагаврын хүрээнд бус харин хэлбэрийн, тулгалт нийлүүлэлтийн шинжтэй, зарим нэг овсгоотой мэдээлэл бүхий ажил хэрэгч хүмүүсийн санаачлага, оролдлогоор бий болж байна гэсэн үг. Тэгээд ч нүүдлийн соёл иргэншлийн нөлөө уламжлал бүхий, дэд бүтцийн хөгжил төдий л сайн бус, мэдээллээс мэдлэг ухаан эрэлхийлдэг сэтгэхүйтэй улс оронд цахим даяарчлал ямархан нөлөө үзүүлэхийг хэн ч хэлж чадахгүй. Гэхдээ би асуудалд өөдрөгөөр хандаж байгаа билээ. Энэ нь монголчууд шашин, бичиг үсэг болон суурин соёл иргэншлийн олон хэв маягийг гаднаас зээлдэн нутагшуулж өвөрмөц басхүү бие даасан ухаан болгож сурсан улс, хоёрт боловсрол мэдлэгийн төвшин, сургалтын тогтолцоо нэгэнт төлөвшсөн гуравт хүн ам цөөн зэрэг нь мэдээллийн нийгмийн төлөвшил илүү бага хугацаа, зардал, хүчээр бий болно хэмээн найдаж байгаа юм.

Мэдээллийн нийгэм хэмээх ойлголт нь компьютертэй байхаас гадна түүнийг ашиглаж хэрэглэж чаддаг мэдлэг чадавхи бүхий иргэдийн амьдрал ахуй орчин

юм. Нэн ялангуяа эдийн засаг, банк санхүүгийн салбарт мэдээллийн технологийн нэгдэлжилт, түүний нөлөө хүчин зүйл бодитой, зайлшгүй байх нь онцгой чухал гэгддэг. Хүн төрөлхтний түүх бол материаллаг баялгийг бүтээхийн төлөөх бэрхшээл саадын эсрэг хийсэн тэмцэл ялагдал бас ялалтын он цагийн товчоо тэхдээ оюун санаа мэдлэгийг баялаг иргэншил болгох агуу их үйл хэрэг байсныг бид хүлээн зөвшөөрөх цаг болжээ. Анх "нүдэнд харагдаж гарт баригддаггүй ор үгүй хоосон хугацаа"-г хэмжих цаг хэмээх нэгжтэй болсон нь европт бол шашин шүтлэг мөргөлтэй холбоотой, харин манайд зурхайн ухаан байжээ. Энэ бол мэдээж хүний оюун санаа мэдлэгийн үр жимс байсан. Харин цаг хугацааны эдийн засгийн утгыг тогтоож баялаг болгосон нь жинхэнэ түүх юм. Ийм өнөөгийн энгийн жишээ нь олон улсын нислэгийн тийз борлуулах төвийг 100 сая төгрөгийн зээл аван нээж, интернетийн сүлжээг ашиглан ашиг орлого олж буй залуугийн бизнесийн түүх юм. Тэр юу зарж байна вэ? Ердөө л үйлчлүүлэгчдийнхээ цаг хугацаа, мэдээллийг л худалдаалж сууна. Мөн эрэлт хэрэгцээг баялаг болгож байна. Гэхдээ хамгийн гол нь бидний яриад байгаа мэдээллийн технологийг ашиглажээ. Үүнийг би жинхэнэ мэдээллийн нийгэм гэж хэлмээр байна. Өөрөөр хэлбэл, компьютерийн хэрэглээ, түүний чадвар чадавхийн үр дүн, ач холбогдлын төвшинг баялаг болгож буй эсэхээр, тийм орчин бүрдснээр тодорхойлно гэсэн үг. Тиймээс бидний монголчуудын компьютерээр и-мэйл шалгах, захиа бичих, Шрек-2 тоглох бол мэдээллийн нийгмийн дүр төрх огтоос биш юм. Хэрэв хиам чанахад, ундааны сав хийхэд, гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлахад, Сонины дизайны лекц уншихад компьютер оролцож байвал мэдээллийн нийгэм мөн

харин үгүй байвал биш гэсэн хэрэг болно. Энгийнээр хэлбэл, мэдээллийн технологийн оролцоо нөлөө хэзээ эдийн засгийн хөдөлгөгч хүч болно тэр цагт бид нийгмийн тухай ярих болох нь ээ. Мэдээж ийм нөхцөл Өрнөд Европ, Америкт бодит зүйл болсон. Харин манайд асуудал ямар байгааг бид мэднэ. Эдийн засгийн хямрал, улс төрийн тогтворгүй байдал, нийгмийн харанхуйлал, сэтгэхүйн хоосрол дээр авилга шудрага бус төрийн дарангуйлал ямар нэг хэмжээгээр оршсоор байна.

Мэдээллийн нийгэмд мэдээллийн бизнес тэргүүлэгч болохыг нотлох баримт олон. Энэ нь ч зүй ёсны үзэгдэл юм. Радио 50 сая сонсогчтой болохын тулд 38 жил хөгжим, жүжиг, ток шоу нэвтрүүлэг цацсан бол, телевиз 13 жил кино, мэдээллийн хөтөлбөр үзүүлж харин ийм тооны хэрэглэгчтэй бо-

лохын тулд интернет ердөө 4 жил зарцуулжээ. Гайхамшгийн нууц нь нэг талаас радио эхлэлийг нь тавьж, телевиз төлөвшүүлсэн мэдээллийн даяарчлал, нөгөө талаас мэдээллийн эдийн засгийн бодит орчин байв. Мэдээж дээрхи хүчин зүйлийг холбосон мэдээллийн технологийн хөгжил, харилцаа холбооны аварга сүлжээг хэлэх хэрэгтэй. Товчилбол уламжлалт нийгэмд баялагийг бүтээх хэрэгсэл нь хэл, дундад зуунд бичиг үсэг харин өдгөө цахим мэдээллийн сан болжээ. Энэхүү дүгнэлтийг батлах гайхамшигтай түүх нь дэлхийн мэдээллийн санг

"үйлдвэрлэгч" Майкрософтын түүх юм. XXI зууны тэргүүлэгч компани 1975 онд буюу байгуулагдсан жилийнх нь ашиг ердөө 16 мянган америк доллар байв. Харин мэдээллийн эриний эхлэл тавигдсан 1991 онд ашиг нь 2 тэрбумд хүрч 2000 он гэхэд 15 тэрбум давжээ⁵. Ажиллагсдын тоо ч нэгээс 30 мянга хол давтлаа өсчээ. Интернетийн программ хангамжийн тэргүүлэгч болох Cisco компанийн эрэгэлтийн хөрөнгө 1995-1999 хооронд 2,2 тэрбумаас 12,2 тэрбум америк доллар боллоо өсчээ. Интер-

нетээр ашиг олох бизнес ч цэцэглэж, дэлгэцээр дамжих мөргөний тоо 2002 онд 1 триллион 200 тэрбумд хүрчээ⁶. Мэдээллийн технологийн хөгжил сэтгүүл зүйд шууд нөлөөлөв. Анхны сонин хэвлэгдэж байсан үеэс олон зүйл өөрчлөгджээ. Олон нийтийн харил-

цааны томоохон онолч Херберт Маршалл Маккулейн "...бичиг үсгээр цаг үе, үйл явдал, баримтыг тэмдэглэгч сонин эринд хүмүүсийн харахуйн сэтэхүй хомсдож, "нүд чихийг орлон гажуудуулж" байсныг телевиз өөрчлөн сэтэхүйн мэдээллийн хэсэгчилсэн ядмаг байдлыг үгүй болгоод аливаа утгыг бүхэл цогцоор мэдрэх боломжийг бий болголоо" хэмээн аль 1960-аад оны эхэн үед тэмдэглэж байжээ. Харин өдгөө интернет зөвхөн нэг үйл явдлыг бус харин дэлхийн хэмжээний баримт үзэгдэл асуудлыг

«

Радио 50 сая сонсогчтой болохын тулд 38 жил хөгжим, жүжиг, ток шоу нэвтрүүлэг цацсан бол, телевиз 13 жил кино, мэдээллийн хөтөлбөр үзүүлж харин ийм тооны хэрэглэгчтэй болохын тулд интернет ердөө 4 жил зарцуулжээ. Гайхамшигийн нууц нь нэг талаас радио эхлэлийг нь тавьж, телевиз төлөвшүүлсэн мэдээллийн даяарчлал, нөгөө талаас мэдээллийн эдийн засгийн бодит орчин байв.

цогц, иж бүрнээр хүргэх боломж нөхцөлийг бий болгож байна.

2000 онд Америкийн төдийгүй дэлхийн мэдээллийн "аварга загас" Тайм-Уорнер" корпораци өөртөө "Американ Онлайн" хэмээх өөрийнх нь нэгдэлд байдаг "Уорнер Бразерс" гэдэг кино үйлдвэрлэгч компанаас 2 дахин бага үнэтэй сүлжээг нэгтгэсэн нь учиртай. Анх 1989 онд америкийн сэтгүүлийн магнат "Тайм инк" кино үйлдвэрлэлийн тэргүүлэгч компани "Уорнер Бразерс"-той нэгдэхэд шоу бизнесийн шинэ эхэлснийг зарлаж байсан бол, 1995 онд "Тайм Уорнер" алдарт Тед Тернерийн "Ти-Би-Эс"-ийг нэгтгэснээр телевиз төвт мэдээллийн бизнес эхэлснийг нэрлэж байсан бол, 2000 онд болсон дээрхи үйл явдлыг мэдээллийн даяарчлалын эрин хэмээж байжээ⁷. Мөн энэ онд Францын үндэстэн дамжсан мэдээллийн корпораци "Виванди" Канадын мэдээлэл харилцааны оператор сүлжээ болох "Сиграм"-ыг нэгтгэсэн нь бас нэгэн томоохон үйл явдал байв. Харин Монголын сэтгүүл зүйд сонин тэргүүлэгч байр сууриа хадгалсаар байгаагийн жишээ нь улсын бүртгэлтэй нийт мэдээллийн хэрэгслийн 90 гаруй хувийг эзэлж буй байдал⁸, олон нийтийн санаа бодолд үзүүлж байгаа нөлөөллийн өндөр төвшин зэргээс харж болно. Хэдийгээр тоон технологийн телевиз хүртэл гарч, FM-үүд олширч, интернетийн хэрэглэгчдийн тоо өсч байгаа ч нэгдмэл мэдээллийн тогтолцоо болтлоо нилээд хугацаа хүч хөрөнгө шаардагдах нь ойлгомжтой. Үүнд эдийн засгийн хямрал, нийгэм улс төрийн сөрөг нөлөө гээд олон хүчин зүйлийг ч тооцох хэрэгтэй. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалт тодруулбал дэлхийн хэмжээний мэдээллийн компанийн Монгол дахь салбар гэсэн хувилбараар технологийн хоцрогдлыг даван гарах, эдийн засаг санхүүгийн бэрхшээлийг зохицуулах,

улмаар мэдээллийн харилцааны нэгдмэл тогтолцоог бий болгох хэрэгтэй байна. Энэ нь сэтгүүлзүйн хөгжилд ч зэрэг хөрөнгө оруулалт болох нь гарцаагүй. Ийм нөхцлийг бүрдүүлэхэд хууль эрхзүй эдийн засаг татварын таатай орчин юу юунаас чухал гэдэг нь ойлгомжтой.

Мэдээллийн нийгэм бол мэдлэг бүхий хүмүүсийн нийтлэг юм. Өөрөөр хэлбэл дээр дурдсан мэдээллийн "асар том сан"-гаас хэрэгтэй, чухал зайлшгүй мэдээллээ сонгох, олох чадвар мэдлэг бүхий хэрэглэгчийн нийгэм болой. Үнэхээр ч бидний гол бэрхшээл мэдээллийн хомсдолд бус харин мэдээллийн дарангуйлалд орших боллоо. Нөгөө талаар мэдээллийн нээлттэй байдал нь зохиогчийн эрх, хувь хүний нууцын хамгаалал, садар самуун хүчирхийллийн сурталчилгаа гээд олон шинэ шинэ зөрчилт асуудлыг бий болгоод байна. Үүнд өнгөрсөн хавар манай нийгмийг шуугиулсан нүцгэн охидын зураг бүхий веб сайтаас фашизмыг сурталчилсан 1000 гаруй вэб сайт байдаг, терроризмын бодит аюул Интернетэд нүүрлээд байгаа хүртэлх жишээ баримтыг дурдаж болно. Түүнчлэн мэдээллийн хүрээнд нийгмийн анги бүлгийн тэгш бус, ялгаат байдал бий болж, үүнээс шалтгаалан ялгаварлан гадуурхах үзлийн шинэ хандлага төлөвшиж буй, улмаар улс орныг хамарсан хямрал зөрчлийн томоохон угшил болон ужгирч байгааг ч тэмдэглэх нь зүйтэй. Хэдийгээр эдгээр тулгамдсан асуудал нь бидний хувьд холын, үл мэдэгдэм зүйл мөн ч нэгэнт эхлэлээ тавьсан шинэ иргэншил болох мэдээллийн нийгэм нь дэлхий дахинаа ямар хурдацтай, өргөн хүрээг хамарч буйг анзаарч өдгөөгөөс тодорхой бодлого зохицуулалтаа тодорхойлох нь зүйтэй юм. Ирээдүйн хямралаас гарах бодит алхам нь ч хүнээ бэлтгэх,

төлөвшүүлэхээс эхлэх нь ойлгомжтой. Энд хууль, төрийн зохицуулалт, нийгмийн дэмжлэг чухал. Өөрөөр хэлбэл, хэрэгтэй зайлшгүй мэдээллээ олж чаддаг мэдлэг чадвар бүхий хүн байж сая мэдээллийн нийгэм оршино гэсэн үг. Уламжлалт нийгэм нь ухамсар, хэл яриатай хүнийг, харин аж үйлдвэржилтийнх нь бичиг үсэг мэддэг, техникийн боловсролтой хүнийг төлөвшүүлдэг бол мэдээллийн нийгэм нь компьютер, мэдээллийн сантай харьцах мэдлэг боловсрол бүхий хүний иргэншил болно. Гэтэл саяхан БСШУЯ-наас зарласан ерөнхий боловсролын бүх сургуулийг компьютержүүлсэн тухай дүнг харахад "нэг сургуульд нэг компьютер"⁹ гэсэн зарчмаар асуудлыг шийдсэн байх юм. Бас болоогүй зарим ганц нэг сургуульд хүрээгүй гэж байгаа. Тэнд багш нь самбар дээр компьютер зураад сурагчид нь цээжлээд нэг юм хичээл сургалт явж байгаа. Нөгөө гайхуулаад байсан нэг ширхэг Пентиум-1 нь захирлын ч юм уу эсвэл багшийн өрөөнд тоосонд дарагдаад хэвтэж байх. Ийм л нэг дүр зураг, байдлаар бид шинэ нийгмийн хүнээ бэлтгэж байна. Төсвийн байгууллагуудад хүч чадамж муу компьютерийг өндөр үнээр шахдаг бизнес цэцэглэж, их дээд сургуульд процессорийн бүтэц зааж байх хооронд мэдээллийн технологийн хувьсал, өөрчлөлт улам бүр явагдсаар л байна. Гэхдээ компьютер байхгүй, мэдэхгүй байна гэдэг бол асуудлын нэг л тал. Түүний цаана сэтгэлгээний, улс орны хөгжлийн, цаашилбал хүний хөгжлийн хоцрогдол оршиж байгаа. Өөрөөр хэлбэл бидний ярих ёстой зүйл нь өндөр хурдтай, багтаамж сайтай компьютер бус, харин хүмүүсийн мэдлэг чадавхийн төвшин, мэдээллийн сонгох чадамжтай нийгмийн сайн "шүүлтүүр" болоод байна гэсэн үг.

Мэдээж энэхүү өгүүлэл нь мэдээллийн нийгэм хэмээх ойлголтыг бүхэлд тодорхойлж чадахгүй юм. Амьдралд байдаг сайн хийгээд муу тал, бодит болоод хийсвэр хүчин зүйл мэдээллийн нийгэмд ч бий. Эдийн засаг нийгмийн эрс хөгжил, амьдралын хэмнэлийн хурд, даяарчлагдсан мэдээллийн орон зай, санхүү бизнесийн шинэ боломжууд мэдээж сэтгүүл зүйн цоо шинэ дэвшил гээд олныг өгүүлж болно. Дашрамд тэмдэглэхэд өнөөгийн дэлхийн сэтгүүл зүй нь мэдээллийн технологийн суурин дээр урьд хэзээ ч байгаагүй хурд, агуулгын багтаамж, нөлөөллийн хүрээг хамарсан тогтолцоо болоод байгаа билээ. Гэхдээ сөрөг хямарлын шинжтэй зүй тогтол ч бий. Жинхэнэ дайныг кино шиг үзүүлдэг, хар салхийг улс орнуудад айлчлуулдаг, ерөнхийлөгчийн хувийн амьдралыг дэлхийн хэмжээний асуудал болгодог гэм бий. Мэдээллийн нийгмийн хувьд ч амьдралын хэмнэлийн хурд нэмэгдснээр чөлөөт ба ажлын цаг хоорондын ялгаа үгүй болсон, сэтгэл зүйн хямрал өвчинд өртөмтгий хүнийшсэн ганцаардмал сэтгэхүй ноёрхох болсон, гэр бүлийн харилцааны үнэт зүйлс алдагдсан, хүүхэд залуусын нийгэмшилтэд хямрал нүүрлэх болсон гээд олон асуудлыг ярьж бичиж байна. Энэ бол өрнөдийн нийгмийн сүүдэр харин бидний бол гэрэл гэгээтэй тал. Тэгээд ч хүний мөн чанар, цэвэр оюун ухааны төлөө мэдээллийн урсгалыг хязгаарлах хэрэгтэй гэсэн уриа гарчээ. Гэхдээ бид энд хүрэхэд хаа ч байсан юм билээ. Тиймээс бидэнд нийгмийн хөгжлийн "сайн" эхлэлийг тавих боломж нөхцөл бас чиг байна гэсэн үг. Нэгтгэн үзвэл мэдээллийн нийгэм нь компьютер түүнийг тойрсон мэдээллийн орчин, мэдээллийн эдийн засгийн бодит тогтолцоо, түүнийг хэрэглэгчийн мэдлэг чадвар бүхий хүний иргэншил ажээ.

Ишлэл

- ¹ Эриксен Т. Х. Тирания момента. М. 2003. С. 50.
- ² Вартанова Е. Л. Европейские неравенства эпохи интернета. Вестник МГУ. Сер. 10. 2001. №6. С. 14.
- ³ http://www.nua.ie/surveys/how_many_online/europe.html.02.07.01.
- ⁴ Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өнөөгийн байдал хэтийн төлөв (ДБЯ-ны 2003 оны жилийн эцсийн тайлан).
- ⁵ www.microsoft.com.
- ⁶ Эриксен Т. Х. Тирания момента. М. 2003. С.120.
- ⁷ Засурский Я. Н. Мировое информационное пространство в 2000 году. Вестник МГУ. Серия 10. 2001. № 5. С. 52.
- ⁸ ХЗДХЯ-ны 2003 оны тайлан мэдээлэл.
- ⁹ МҮТВ-ийн шууд нэвтрүүлэгт БСШУЯ-ны сайд А.Цанжидийн 2004 оны 6-р сард өгсөн мэдээлэл.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Вартанова Е. Л. Европейские неравенства эпохи интернета. Вестник МГУ. Сер. 10. 2001. №6.
2. Засурский Я. Н. Мировое информационное пространство в 2000 году. Вестник МГУ. Серия 10. 2001. № 5.

3. Мэдээлэл, холбооны үндсэн сүлжээний өнөөгийн байдал хэтийн төлөв (ДБЯ-ны 2003 оны жилийн эцсийн тайлан).
4. ХЗДХЯ-ны 2003 оны тайлан мэдээлэл.
5. Эриксен Т. Х. 2003. Тирания момента. М.
6. http://www.nua.ie/surveys/how_many_online/europe.html.02.07.01.
7. <http://www.microsoft.com>.

Резюме

В данной статье автор выдвигает свою идею о том, что информационное общество есть компьютер, а также образовавшаяся вокруг него информационная среда, реальная экономическая информационная структура и потребитель в лице человека, обладающего для этого необходимыми качествами. Автор в ходе исследования приходит к выводу, что при формировании современного монгольского общества одну из ключевых ролей играют не социально-экономические факторы, а деятельность и инициатива деловых людей, принимающие характер навязывания.